



**НИЙСЛЭЛИЙН БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2023 оны 05 сарын 19 өдөр

Дугаар А/105

Улаанбаатар хот

**Бүх нийтээр мод тарих хөдөлгөөнийг
өрнүүлэх тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 77 дугаар зүйлийн 77.1, Ойн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралтын 2.1.5 дахь заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2010 оны “Мод тарих үндэсний өдөр зарлах тухай” 63, 2021 оны “Засгийн газарт чиглэл өгөх тухай” 58 дугаар зарлиг, Нийслэлийн Засаг даргын 2021 оны “Ажлын хэсэг байгуулах тухай” А/908 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Иргэдийн эрүүл, ая тухтай амьдрах орчныг бүрдүүлэх, уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг бууруулах, экологийн тэнцвэрт байдлыг хангах зорилгоор дүүрэгт бүх нийтээр мод тарих хөдөлгөөнийг өрнүүлж, нийтийн эзэмшлийн талбайд мод тарих ажлыг 05 дугаар сарын 12-ны өдрөөс 05 дугаар сарын 29-ний өдөр хүртэл зохион байгуулахыг Тохижилт, худалдаа үйлчилгээний хэлтэс (Д.Хүрэлбаатар)-т үүрэг болгосугай.

2.Дээрх үйл ажиллагаанд шаардагдах хөрөнгийн төсвийг хавсралтаар баталж, 1,300,000 (Нэг сая гурван зуун мянган) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын Ерөнхий нягтлан бодогч (С.Баасанхүү)-д зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцон эргэн танилцуулахыг Засаг даргын Эдийн засаг, нийгмийн хөгжлийн асуудал хариуцсан орлогч (Б.Болормаа)-д, Бүх нийтээр мод тарих хөдөлгөөнийг өрнүүлж, дүүргийн хэмжээнд ажлыг шуурхай зохион байгуулж, тайлан, мэдээг тогтоосон хугацаанд холбогдох газарт хүргүүлж ажиллахыг Тохижилт, худалдаа үйлчилгээний хэлтэс (Д.Хүрэлбаатар)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2023 оны 08 дүгээр сарын 19 ны өдрийн
А/108 дугаар захирамжийн хавсралт



МОД ХУДАЛДАЖ АВАХАД ШААРДАГДАХ
ХӨРӨНГИЙН ТӨСӨВ

Д/д	Барааны нэр	Хэмжих нэгж	Олгох тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ (мян.төг)
1.	Мод (нарс)	ш	10	130,000	1,300,000
Нийт дүн					1,300,000